



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар 01263

Улаанбаатар хот

**“Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн  
газар”-ын данс бүртгэлээс эргэлтийн  
бус хөрөнгө хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 23,494,437.50 /Хорин гурван сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун гучин долоон төгрөг тавин мөнгө/-ний бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг “Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар” /П.Батхүлэг/-т зөвшөөрсүгэй

2. Татан төвлөрүүлж буй 23,494,437.50 /Хорин гурван сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун гучин долоон төгрөг тавин мөнгө/-ний бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, Удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг “Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар” /П.Батхүлэг/-т даалгасугай.


3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2019 оны 07 сарын  
10 өдрийн 0123 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Хүлэмж /төмөр/ ДҮН	7	ш	10	2,349,443.75	23,494,437.50	23,494,437.50	-	татах